

**МОНГОЛ УЛСЫН 2009 ОНЫ ЭХНИЙ  
11 САРЫН ӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2009 оны 11 дүгээр сарын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргалаа. 2009 оны эхний 11 сарын байдлаар нэгдсэн өсвийн нийт орлогын бүрдүүлэлт 94.5 хувийн биелэлттэй, нийт зарлага 91.7 хувийн биелэлттэй гарч улмаар өсвийн нийт алдагдал 361.9 тэрбум төгрөгт хүрсэн байгаа нь төлөвлөсөн дүнтэй харьцуулахад 87.4 тэрбум төгрөгөөр төсвийн алдагдал сайжирсан байна. Засгийн газрын зүгээс хямралын эсрэг төлөвлөгөө гарган ажиллаж байгаа бөгөөд энэхүү төлөвлөгөөний хүрээнд эдийн засгийг тогтворжуулах, макро эдийн засгийг тэлэх чиглэлээр Монголбанктай хамтран өсөв, мөнгөний бодлогыг уялдуулах чиглэлээр хамтран ажиллаж байна. Үүний хүрээнд нийтдээ 106.7 орчим тэрбум өгрөгийг ЗГ - аас банкны салбарт үйлдвэрлэлийг дэмжих, барилгын салбар, алт олборлогчдыг дэмжих, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зэрэг чиглэлээр санхүүжүүлээд байна.

Монгол Улсын Засгийн газар ОУВС-тай байгуулсан өтөлбөр т заасан шалгуур үзүүлэлтүүдээ хангаж ажилласны үр нөлөөгөөр бусад харилцагч донор улс орнуудаас төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулж эхний 11 сарын байдлаар 200.1 тэрбум төгрөгийн хөрөнгө төвлөрөөд байна.

Нэгдсэн төсвийн орлого, зарлагын байдлыг авч үзвэл:

**А. Нэгдсэн төсвийн орлогын бүрдүүлэлт:**

Монгол Улсын нэгдсэн өсвийн нийт орлого 2009 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр 1701.3 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 99.9 тэрбум төгрөгөөр буюу 5.5 хувиар дутуу биелж, 2008 оны мөн үеийнхээс 11.1 хувиар буюу 212.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

**Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг орлогын төрлөөр авч үзвэл:**

ӨСВИЙН ОРЛОГО	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны мөн үеийн	жилийн Төлөв.	2009 ОНЫ 11-Р САР		ХУВЬ		ӨРҮҮ
	1	2	Төлөв.	Гүйцэт.	(4:3)	(4:2)	(4-3)
	(Тэрбум төгрөг)						
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,913.9</b>	<b>2,054.5</b>	<b>1,801.2</b>	<b>1,701.3</b>	<b>94.5</b>	<b>82.8</b>	<b>-99.9</b>
<b>УРСГАЛ ОРЛОГО</b>	<b>1,901.6</b>	<b>2,030.2</b>	<b>1,777.0</b>	<b>1,679.8</b>	<b>94.5</b>	<b>82.7</b>	<b>-97.2</b>
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,687.0</b>	<b>1,697.6</b>	<b>1,484.7</b>	<b>1,403.7</b>	<b>94.5</b>	<b>82.7</b>	<b>-81.0</b>
Орлогын албан татвар	694.3	451.8	389.7	445.7	114.4	98.6	56.0
ААН-ийн орлогын албан татвар	236.7	223.5	201.5	183.1	90.9	81.9	-18.4
Хувь хүний орлогын албан татвар	97.9	98.7	97.1	109.9	113.1	111.4	12.8
Зарим ӨТЭЭГДЭХҮҮНИЙ үнийн өсөлтийн татвар	359.8	129.7	91.1	152.6	167.6	117.7	61.6
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	191.7	251.6	220.2	223.6	101.5	88.9	3.4
Өмчийн татвар	7.4	10.3	9.6	9.4	97.9	91.2	-0.2
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	479.3	629.3	549.0	448.5	81.7	71.3	-100.6
Гадаад худалдааны орлого	136.9	163.2	141.4	105.4	74.5	64.6	-36.0
Бусад татвар	177.4	191.5	174.8	171.2	98.0	89.4	-3.5
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>214.6</b>	<b>332.6</b>	<b>292.3</b>	<b>276.1</b>	<b>94.4</b>	<b>83.0</b>	<b>-16.2</b>
<b>ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	<b>3.8</b>	<b>2.4</b>	<b>4.9</b>	<b>2.6</b>	<b>53.9</b>	<b>110.8</b>	<b>-2.2</b>
<b>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>8.5</b>	<b>22.0</b>	<b>19.4</b>	<b>18.9</b>	<b>97.4</b>	<b>85.9</b>	<b>-0.5</b>

Монгол Улсын нэгдсэн өсвийн орлогыг бүрдүүлж буй эх үүсвэрээр нь авч үзвэл 82.5 хувь нь татварын орлогоос, 16.2 хувь нь татварын бус орлогоос, 1.1 хувь нь тусламжийн орлогоос, 0.2 хувь нь хөрөнгийн орлогоос тус тус бүрдсэн байна.

**Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг төсвийн бүрэлдэхүүнээр харуулвал:**

ТӨСВИЙН ОРЛОГО	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		МУХС		НДС	
	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ
	(Тэрбум.төгрөг )							
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,418.6</b>	<b>1,234.5</b>	<b>225.7</b>	<b>239.5</b>	<b>94.1</b>	<b>156.4</b>	<b>417.1</b>	<b>417.9</b>
УРСГАЛ ОРЛОГО	1,255.0	1,076.1	207.7	223.7	94.1	156.4	278.5	279.3
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>984.0</b>	<b>825.2</b>	<b>189.4</b>	<b>202.3</b>	<b>91.1</b>	<b>152.6</b>	<b>278.5</b>	<b>279.3</b>
Орлогын албан татвар	201.5	183.1	97.1	109.9	91.1	152.6	0.0	0.0
ААН-ийн орлогын албан татвар	201.5	183.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хувь хүний орлогын албан татвар	0.0	0.0	97.1	109.9	0.0	0.0	0.0	0.0
Зарим үгтээгдэхүүний үнийн өсөлтийн а/татвар	0.0	0.0	0.0	0.0	91.1	152.6	0.0	0.0
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	278.5	279.3
Өмчийн татвар	0.0	0.0	9.6	9.4	0.0	0.0	0.0	0.0
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	541.1	439.7	7.9	8.8	0.0	0.0	0.0	0.0
Гадаад худалдааны орлого	141.4	105.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар	100.0	97.1	74.7	74.2	0.0	0.0	0.0	0.0
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>270.9</b>	<b>250.8</b>	<b>18.3</b>	<b>21.5</b>	<b>3.0</b>	<b>3.8</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	0.0	0.0	4.9	2.6	0.0	0.0	0.0	0.0
<b>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>	<b>163.6</b>	<b>158.4</b>	<b>13.2</b>	<b>13.2</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>138.6</b>	<b>138.6</b>

- Улсын төсвийн орлого 1234.5 тэрбум төгрөгт хүрч 13.0 хувиар буюу 184.2 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс дутуу биелсэн байна. Үүнд орлогын албан татварын орлого 9.1 хувиар буюу 18.4 тэрбум, дотоодын бараа, үйлчилгээний албан татвар 18.7 хувиар буюу 101.4 тэрбум, гадаад худалдааны орлого 25.5 хувиар буюу 36.0 тэрбум, татварын бус орлого 7.4 хувиар буюу 20.1 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс дутуу төвлөрсөн нь нөлөөлсөн байна.
- Орон нутгийн төсвийн орлого 239.5 тэрбум төгрөгт хүрч 6.1 хувиар буюу 13.8 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс илүү төвлөрсөн байна. Орлогын албан татварын орлого 13.1 хувиар буюу 12.8 тэрбум, дотоодын бараа, үйлчилгээний албан татварын орлого 11.0 хувиар буюу 0.9 тэрбум, татварын бус орлого 17.3 хувиар 3.2 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс илүү төвлөрч, бусад татвар 0.7 хувиар буюу 0.5 тэрбум, хөрөнгийн орлого 46.1 хувиар буюу 2.2 тэрбум төгрөгөөр тасалдсан байна. Нийслэлийн хувь хүний орлогын албан татварын орлого 8.1 тэрбум, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татварын орлого 0.6 тэрбум төгрөгөөр тус тус давж, газрын төлбөрийн орлого 0.8 тэрбум, хөрөнгийн орлого 2.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелж, нийт дүнгээр 7.3 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс давж биелсэн байна. Орхон аймгийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 2.2 тэрбум, өмчийн татварын орлого 0.2 тэрбум төгрөгөөр тус тус давж, хувьцааны орлогын албан татварын орлого 0.4 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс дутуу биелж, аймгийн дүнгээр 2.1 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс давсан байна. Өмнөговь аймгийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 0.7 тэрбум, хувьцааны ноогдол ашгийн орлого 1.8 тэрбум төгрөгөөр тус тус давж, лицензийн төлбөрийн орлого 1.2 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс дутуу биелж, нийт дүнгээр 1.9 тэрбум төгрөгөөр төлөвлөгөө давж биелсэн. Төв аймгийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого төлөвлөгөөнөөс дутуу биелснээс тус аймгийн нийт орлого 1.6 тэрбум төгрөгөөр тасалдсан байна. Сүхбаатар, Өвөрхангай, Хөвсгөл, Баян-Өлгий, Сэлэнгэ, Увс, Баянхонгор аймгуудын орлого 0.8-0.84 төгрөгөөр төлөвлөгөөнөөс давж, Булган, Архангай, дорноговь, Дархан-Уул аймгуудын орлого 0.4-0.1 тэрбум дутуу биелсэн байна.
- Монгол Улсыг өргөжүүлэх санд алтны үнийн өсөлтийн татварын орлого 152.6 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөөнөөс 61.6 тэрбум төгрөгөөр давсан. Нийгмийн даатгалын

сангийн орлого 417.9 тэрбум болж 0.2 хувиар буюу 0.8 тэрбум өгрөгөөр орлогын төлөвлөгөөг давуулсан. Нийгмийн даатгалын санд улсын төсвөөс олгох 138.6 тэрбум төгрөгийн татаас, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

**Б. Нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилт:** Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2009 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр 2250.5 тэрбум төгрөг, үүнээс улсын төсвийн зарлага 1716.1 тэрбум төгрөг байхаар төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн зарлага 2063.3 тэрбум төгрөг болж, төлөвлөгдсөн нийт зарлагын 91.7 хувийг, улсын төсвийн зарлага 1 582.5 тэрбум төгрөг болж, нийт төлөвлөгдсөн зардлын 92.2 хувийг тус тус санхүүжүүлсэн байна. Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг бүрэн тавьж олгосон бөгөөд халамжийн сангаас хүүхдийн мөнгөний хөтөлбөрт 29.8 тэрбум төгрөг, шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тусламжинд 6.3 тэрбум төгрөг, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох мөнгөн тусламжинд 8.9 тэрбум төгрөг, шинэ гэр бүлд олгох мөнгөн тусламжид 12.4 тэрбум төгрөг, ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт, нэг удаагийн тэтгэмжинд нийт 5.9 тэрбум төгрөг, жирэмсэн нярай эхчүүдэд 1 5.5 тэрбум төгрөгийн, ахмад дайчдын орон сууцны дэмжлэгт 3.0 тэрбум өгрөгийн халамжийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Нэгдсэн төсвийн нийт урсгал зардлын 13.2 хувь буюу 207.3 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн сангийн зардал, 36.1 хувь буюу 566.7 тэрбум төгрөгийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, нийтдээ 49.3 хувь буюу 774.1 тэрбум төгрөгийг цалин, тэтгэвэр тэтгэмжийн зардал эзэлж байна. Орон нутгийн төсвийн зарлага 224.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардлын 91.4 хувийг санхүүжүүлсэн байна. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн зарлага төлөвлөгдсөн зардлын 82.3 хувь буюу 200.8 тэрбум, Нийгмийн даатгалын сангийн зарлага төлөвлөгдсөн зардлын 100.8 хувь буюу 402.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.

### Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

ТӨСВИЙН ЗАРЛАГА	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны мон үеийн	жилийн Төлөв.	2009 ОНЫ 11-Р САР		ХУВЬ	ӨРҮҮ	
	1	2	Төлөв.	Гүйцэт.	(4 : 3)	(4 : 2)	(4 - 3)
	( Тэрбум төгрөг )						
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,076.9</b>	<b>2,378.3</b>	<b>2,250.5</b>	<b>2,063.3</b>	<b>91.7</b>	<b>86.8</b>	<b>-187.3</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,521.2</b>	<b>1,829.9</b>	<b>1,701.4</b>	<b>1,570.6</b>	<b>92.3</b>	<b>85.8</b>	<b>-130.8</b>
<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>894.6</b>	<b>950.3</b>	<b>903.7</b>	<b>840.6</b>	<b>93.0</b>	<b>88.5</b>	<b>-63.1</b>
Цалин хөлс	486.0	581.0	535.5	518.5	96.8	89.2	-17.0
Нийгмийн даатгалын шимтгэл	42.0	55.1	50.8	48.3	94.9	87.6	-2.6
Бараа, үйлчилгээний бусад зардал	408.6	369.3	368.2	322.2	87.5	87.2	-46.1
<b>Зээлийн үйлчилгээний төлбөр</b>	<b>18.2</b>	<b>41.4</b>	<b>31.6</b>	<b>26.0</b>	<b>82.1</b>	<b>62.7</b>	<b>-5.7</b>
Татаас ба шилжүүлэг	608.5	838.1	766.0	703.9	91.9	84.0	-62.1
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>443.5</b>	<b>444.2</b>	<b>457.0</b>	<b>345.9</b>	<b>75.7</b>	<b>77.9</b>	<b>-111.0</b>
Дотоод эх үүсвэрээр:	425.8	412.1	428.7	327.5	76.4	79.5	-101.2
Гадаад эх үүсвэрээр	17.7	32.0	28.2	18.4	65.1	57.4	-9.8
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>112.1</b>	<b>104.3</b>	<b>92.2</b>	<b>146.8</b>	<b>159.2</b>	<b>140.7</b>	<b>54.6</b>
<b>УРСГАЛ ТЭНЦЭЛ</b>	<b>380.4</b>	<b>200.3</b>	<b>75.6</b>	<b>109.2</b>	<b>144.4</b>	<b>54.5</b>	<b>33.6</b>
<b>НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>-162.9</b>	<b>-323.8</b>	<b>-449.3</b>	<b>-361.9</b>	<b>80.6</b>	<b>111.8</b>	<b>87.4</b>

### Эргэж төлөгдөх цэвэр зээл :

Монгол Улсын Засгийн газар 2009 оны 11 дүгээр сарын үйцэтгэлээр олон улсын байгууллага, гадаадын хандивлагч орнуудаас 132.7 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний төслийн зээлийн хөрөнгийг авч ашиглахаар төлөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд 74.1 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний эх үүсвэрийг авч ашигласан гүйцэтгэл гарчээ.

**Төсвийн тэнцэл:**

Тайлант үед Монгол Улсын нэгдсэн өсвийн урсгал тэнцэл 109.2 тэрбум төгрөг ийн ашигтай, нийт тэнцэл 361.9 тэрбум төгрөгийн алдагдалтай, улсын төсвийн урсгал тэнцэл 154.5 тэрбум, нийт тэнцэл 348.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Төсвийн нийт алдагдлыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлж урсгал болон хөрөнгө оруулалтын санхүүжилтийг цаг хугацаанд нь бүрэн төлж барагдууллаа.

Үүнд: 1. МУ-н өсвийн тухай хуулийн хүрээнд Монгол Улсыг хөгжүүлэх сангийн эрсдлийн хэсгээс 219.6 тэрбум төгрөгийн,

2. Донор болон хандивлагч улс орнуудаас 200.1 тэрбум төгрөгийн эх үүсвэрүүдийг бүрдүүлсэн байна.

Мөн Монгол Улсын Засгийн газар, Айвенхоу майнз ХХК, Риотинтогийн хооронд байгуулсан Оюутолгой өслийн гэрээний хүрээнд 100.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний ЗГ-н бондын урьдчилгаа төлбөр Улсын төсвийн харилцах дансанд төвлөрсөн байна.

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН 2009 ОНЫ ЭХНИЙ 11 САРЫН  
БАЙДЛААРХ ТӨСВИЙН ГҮЙЦЭТЭЛ**

Монгол Улсын төсвийн 2009 оны эхний 11 сарын төсвийн гүйцэтгэлээр нийт төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн гүйцэтгэлийг авч үзэхэд ХЗДХСайд болон Сангийн сайдын төсвийн багцын нийт зардлын дүн батлагдсан төсвөөс хэтэрсэн байна.

Энэ нь дараах хүчин зүйлээс шалтгаалжээ. Үүнд:

**А. Сангийн сайдын төсвийн багц**

/сая.төг/

ТӨСВИЙН ГҮЙЦЭТЭЛ	Телевлегее /ессенді нгээр/	Гүйцэтгэл /ессенді нгээр/	Хэмнэлт (+) Хэтрэлт (-)
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	220,186.8	247,225.0	(27,038.23)
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	113,593.2	93,549.8	20,043.43
<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	66,322.1	52,490.5	13,831.59
Цалин, өлс	24,817.7	21,457.1	3,360.54
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	2,733.2	2,377.1	356.10
Бараа, үйлчилгээний бусад зардал	38,771.3	28,656.4	10,114.95
<b>Зээлийн үйлчилгээний өлбөр</b>	31,643.0	25,992.4	5,650.66
<b>Татаас ба урсгал үүсгэл</b>	15,628.1	15,066.9	561.17
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	16,350.0	9,506.9	6,843.14
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	90,243.6	144,168.4	(53,924.80)

Улсын төсвийн 2009 оны 11 дүгээр сарын гүйцэтгэлээр Сангийн сайдын төсвийн багцын зарлага 27.0 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь эргэж телегдэх цэвэр зээл 53.9 тэрбум төгрөгөөр хэтэрсэнтэй шууд холбоотой байна. Энэ нь олон улсын санхүүгийн зах зээл дээр Монгол Улсын Засгийн газраас нийт 94.7 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний бондыг арилжиж, дотоодын алтны үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор арилжааны банкуудаар дамжуулан зээлдүүлсэн нь эргэж телегдэх цэвэр зээлийн хэтрэлтэд нелеелсэн байна.

**Б. Хууль зүй, дотоод хэргийн сайд**

/сая.төг/

ТӨСВИЙН ГҮЙЦЭТЭЛ	Телевлегее /ессенді нгээр/	Гүйцэтгэл /ессенді нгээр/	Хэмнэлт (+) Хэтрэлт (-)
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	83,854.86	100,674.89	(16,820.03)
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	103,067.70	100,721.76	2,345.94
<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	95,597.38	93,489.81	2,107.56
Цалин, өлс	63,730.25	63,334.75	395.50
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	3,024.86	2,860.87	163.99
Бараа, үйлчилгээний бусад зардал	28,842.27	27,294.19	1,548.08
<b>Татаас ба урсгал үүсгэл</b>	7,470.32	7,231.95	238.37
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	7,370.50	5,353.13	2,017.37
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	(26,583.33)	(5,400.00)	(21,183.33)

Улсын төсвийн 2009 оны 11 дүгээр сарын гүйцэтгэлээр ХЗДХСайдын багцын зарлага 16.8 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь ХЗДХСайдын багц дахь хадгаламж зээлийн хоршоодын хохирогчдын хохирлыг барагдуулахад олгосон зээлийн буцаан төлөлт 26.6 тэрбум төгрөг байхаар төвлөснөөс 21.2 тэрбум төгрөгөөр дутуу буюу 5.4 тэрбум төгрөг төвлөрсөнтэй холбоотойгоор төсөвлөгдсөн нийт зарлага хэтэрсэн харагдах нөхцөл бүрдсэн байна.

